# ЗАВСРЫН ҮЕИЙН ХУРААНГУЙ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 болон 2023 оны 09 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон гурван сар ба есөн сарын тайлан

*(Канад доллараар)*
*(Аудитаар баталгаажаагүй)*

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу

## УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажаагүй завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайланг Компанийн удирдлага бэлтгэсэн. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2022 оны 12 сарын 31 болон 2023 оны 9 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2022, 2023 оны 9 сарын 30-аар дуусгавар болсон 3 ба 9 сарын хугацааны нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2022, 2023 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, Нэгтгэсэн Завсрын Санхүүгийн Тайлан**
(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодруулга | | 2023.09.30 | | 2022.12.31 |
|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | | $ | **28,283,697** | $ | 7,421,600 |
| Дансны авлага | | | **77,144** | | 76,582 |
| Урьдчилж төлсөн авлага | | | **1,781,382** | | 1,361,730 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | | **30,142,223** | | 8,859,912 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | **4** | | **63,140,652** | | 43,054,156 |
| Хөрөнгө ашиглах эрх | **5** | | **26,924** | | 73,594 |
| Үндсэн хөрөнгө | **6** | | **933,809** | | 545,704 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | | **64,101,385** | | 43,673,454 |
| **Нийт хөрөнгийн дүн** | | **$** | **94,243,608** | **$** | 52,533,366 |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | | | | |
| Арилжаа болон бусад өглөг | | $ | **11,771,151** | $ | 826,409 |
| Түрээсийн өмч | **5** | | **31,295** | | 59,662 |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг | **8** | | **33,953,736** | | - |
| Эргэлтийн өр төлбөр | | | **45,756,182** | | 886,071 |
| Түрээсийн өмч | **5** | | **-** | | 22,940 |
| Эргэлтийн бус өр төлбөр | | | **-** | | 22,940 |
| **Өр төлбөрийн нийт дүн** | | | **45,756,182** | | 909,011 |
| **Эздийн өмч** | | | | | |
| Хувьцаат капитал | **9** | $ | **157,918,219** | $ | 157,880,069 |
| Нэмж төлөгдсөн капитал | **9** | | **30,214,274** | | 28,727,197 |
| Бусад хуримтлагдсан алдагдал | | | **(5,768,524)** | | (5,952,986) |
| Алдагдал | | | **(133,876,543)** | | (129,029,925) |
| **Эздийн өмчийн дүн** | | | **48,487,426** | | 51,624,355 |
| **Өр төлбөрийн ба эздийн өмчийн дүн** | | $ | **94,243,608** | $ | 52,533,366 |

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 7)
Тайлант хугацаанд өрнөсөн үйл явдлууд (Тодруулга 8)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Жон П.Бюрн"
____________________________________ ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Кеннет В.Макдоналд"
____________________________________ ТУЗ-ийн гишүүн

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, Нэгтгэсэн Завсрын Алдагдлын Дэлгэрэнгүй Тайлан**

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

| | | 9.30-аар дуусгавар болсон гурван сар | | 9.30-аар дуусгавар болсон есөн сар | |
|---|---|---|---|---|---|
| | **Тодруулга** | **2023** | **2022** | **2023** | **2022** |
| **Үйл ажиллагааны зардал** | | | | | |
| Хайгуул, үнэлгээни зардал | **10** | **$ 689,226** | $ 1,155,249 | **$ 2,242,586** | $ 3,148,957 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | **11** | **600,595** | 870,287 | **2,572,161** | 1,791,332 |
| Үйл ажиллагаанаас учирсан алдагдал | | **1,289,821** | 2,025,536 | **4,814,747** | 4,940,289 |
| Санхүүгийн орлого | | **(69,283)** | (26,588) | **(235,547)** | (37,858) |
| Хүүгийн зардал | | **(516,848)** | 2,524 | **3,478** | 9,039 |
| Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан (олз)гарз | | **496,410** | (21,034) | **263,940** | (2,128) |
| **Цэвэр алдагдал** | | **$ 1,200,100** | $ 1,980,438 | **$ 4,846,618** | $ 4,909,342 |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | | | | |
| Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү | | **(823,527)** | (68,953) | **(184,462)** | 1,682,704 |
| **Бусад дэлгэрэнгүй алдагдал** | | **(823,527)** | (68,953) | **(184,462)** | 1,682,704 |
| **Нийт дэлгэрэнгүй алдагдал** | | **$ 376,573** | $ 1,911,485 | **$ 4,662,156** | $ 6,592,046 |
| Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал | | **$ -** | $ 0.01 | **$ 0.01** | $ 0.02 |
| Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо | | **344,415,884** | 314,830,239 | **344,363,111** | 301,288,696 |

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, Нэгтгэсэн Завсрын өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодр уулга | Хувьцааны тоо ширхэг | | Хувьцаат капитал | | Нэмж төлөгдсөн капитал | | Хуримтлагдсан бусад дэлгэнгүй алдагдал | | Алдагдал | | Нийт эздийн өмч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2023.01.01-ний үлдэгдэл | | **344,300,376** | $ | **157,880,069** | $ | **28,727,197** | $ | **(5,952,986)** | $ | **(129,029,925)** | $ | **51,624,355** |
| Тайлант хугацааны нийт алдагдал: | | | | | | | | | | | | |
| Цэвэр алдагдал | | **-** | | **-** | | **-** | | **-** | | **(4,846,618)** | | **(4,846,618)** |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | **-** | | **-** | | **-** | | **184,462** | | **-** | | **184,462** |
| Хэрэгжүүлсэн опцион | **9** | **100,000** | | **31,400** | | **(11,400)** | | **-** | | **-** | | **20,000** |
| ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу гаргасан энгийн хувьцаа | | **17,614** | | **6,750** | | **(6,750)** | | **-** | | **-** | | **-** |
| Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр | | **-** | | **-** | | **1,505,227** | | **-** | | **-** | | **1,505,227** |
| Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ | | **117,614** | | **38,150** | | **1,487,077** | | **-** | | **-** | | **1,525,227** |
| 2023.09.30-ний үлдэгдэл | | **344,417,990** | $ | **157,918,219** | $ | **30,214,274** | $ | **(5,768,524)** | $ | **(133,876,543)** | $ | **48,487,426** |
| 2022.01.01-ний үлдэгдэл | | 294,379,845 | $ | 145,153,510 | $ | 26,648,556 | $ | (3,026,358) | $ | (123,043,688) | $ | 45,732,020 |
| Тайлант хугацааны нийт алдагдал: | | | | | | | | | | | | |
| Цэвэр алдагдал | | - | | - | | - | | - | | (4,909,342) | | (4,909,342) |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал | | - | | - | | - | | (1,682,704) | | - | | (1,682,704) |
| Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зард | 9 | 23,933,687 | | 6,551,072 | | 413,713 | | - | | - | | 6,964,785 |
| Хэрэгжүүлсэн опцион | 9 | 60,000 | | 23,400 | | (6,300) | | - | | - | | 17,100 |
| Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр | | - | | - | | 921,712 | | - | | - | | 921,712 |
| Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ | | 23,993,687 | | 6,574,472 | | 1,329,125 | | - | | - | | 7,903,597 |
| 2022.09.30-ний үлдэгдэл | | 318,373,532 | $ | 151,727,982 | $ | 27,977,681 | $ | (4,709,062) | $ | (127,953,030) | $ | 47,043,571 |

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, нэгтгэсэн завсрын мөнгөн гүйлгээний тайлан**
(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодруулга | 9.30-аар дуусгавар болсон гурван сар 2023 | 9.30-аар дуусгавар болсон гурван сар 2022 | 9.30-аар дуусгавар болсон есөн сар 2023 | 9.30-аар дуусгавар болсон есөн сар 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагаан мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Цэвэр алдагдал | | $ **(1,200,100)** | $ (1,980,438) | **(4,846,618)** | $ (4,909,342) |
| Мөнгөн бус гүйлгээнүүд | | | | | |
| Элэгдэл, хорогдол | | **32,484** | 34,965 | **110,052** | 100,557 |
| Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр | | **295,002** | 763,718 | **1,505,227** | 921,712 |
| Санхүүгийн орлого | | **(69,283)** | (26,588) | **(235,547)** | (37,858) |
| Мөнгөн бус гадаад валют | | **496,410** | (21,034) | **263,940** | (2,128) |
| Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт | | **11,218,414** | (519,363) | **10,529,855** | (382,735) |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **10,772,927** | (1,748,740) | **7,326,909** | (4,309,794) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн | 9 | **-** | 6,964,785 | **-** | 6,964,785 |
| Опцион хэрэгжүүлсэн төлбөр | 9 | **-** | - | **20,000** | 17,100 |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг | 8 | **20,198,340** | - | **33,727,003** | - |
| Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт | | **(8,223)** | (16,023) | **(50,703)** | (46,844) |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн хүү | 8 | **(517,385)** | - | **-** | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **19,672,732** | 6,948,762 | **33,696,300** | 6,935,041 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал | 4 | **(14,684,602)** | (2,612,643) | **(20,046,818)** | (6,555,922) |
| Үндсэн хөрөнгийн зардал | 6 | **(109,890)** | (69,297) | **(447,706)** | (185,837) |
| Хүүгийн орлого | | **69,283** | 26,588 | **235,547** | 37,858 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **(14,725,209)** | (2,655,352) | **(20,258,977)** | (6,703,901) |
| Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | | **308,435** | 40,414 | **97,865** | (3,854) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт) | | **16,028,885** | 2,585,084 | **20,862,097** | (4,082,508) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд | | **12,254,812** | 395,459 | **7,421,600** | 7,063,051 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд | | $ **28,283,697** | $ 2,980,543 | **28,283,697** | $ 2,980,543 |

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

1. **Үйл ажиллагаа:**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ("Эрдэнэ Ресурс" "Корпораци" эсвэл "Компани" гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр "ERD", Монголын Хөрөнгийн Бирж дээр "ERDN" тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

2023 оны 9 дугаар сард Эрдэнэ Ресурс нь Баянхөндий Алтны Төслийн шинэчилсэн ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. Компанийн төслүүдийн ашиглалтын хугацаа, ашигт малтмалын капиталжуулсан хөрөнгийн ашиглалт зэрэг нь нөөцийн эдийн засгийн өгөөж, компанийн хайгуул, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг олох чадвар болон үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай байдал эсвэл нэг буюу түүнээс дээш хөрөнгийн худалдаанаас олсон орлого зэргээс хамаарна.

2. **Тайлангийн үндэслэл**

2023 оны 9 дугаар сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг ("Завсрын үеийн санхүүгийн тайлан") Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС") 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу боловсруулагдсан 2022 оны 12 дугаар сарын 31- нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан ("Жилийн эцсийн санхүүгийн тайлан")-тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайланг тайлагнахыг 2023 оны 11 дугаар сарын 7-ний өдөр ТУЗ-өөр зөвшөөрсөн болно.

3. **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд**

2023 оны 1 дүгээр сарын 1-ээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

<u>НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн толилуулга</u>

2020 оны 1 сарын 23-нд НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

## 4. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

| | Баянхөндий | Алтан Нар | Улаан | Зуун мод ба бусад | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 2023.01.01 үлдэгдэл | **$ 36,183,734** | **$ 4,257,954** | **$ 1,688,477** | **$ 923,991** | **$ 43,054,156** |
| Нэмэгдэл | **18,978,731** | **69,493** | **1,495** | **997,099** | **20,046,818** |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | **24,873** | **1,951** | **775** | **12,079** | **39,678** |
| 2023.09.30 үлдэгдэл | **$ 55,187,338** | **$ 4,329,398** | **$ 1,690,747** | **$ 1,933,169** | **$ 63,140,652** |
| | | | | | |
| 2022.01.01 үлдэгдэл | $ 30,910,999 | $ 4,246,301 | $ 1,797,500 | $ 973,653 | $ 37,928,453 |
| Нэмэгдэл | 7,628,060 | 288,818 | 1,726 | 53,351 | 7,971,955 |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | (2,355,325) | (277,165) | (110,749) | (103,013) | (2,846,252) |
| 2022.12.31 үлдэгдэл | $ 36,183,734 | $ 4,257,954 | $ 1,688,477 | $ 923,991 | $ 43,054,156 |

Компанийн Монгол Улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

Баянхөндий Алтны Төсөл

Баянхөндий Алтны Төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, 2,309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог ба 2019 оны 8 сард Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ) нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 2023 оны 9 сарын 25-нд танилцуулсан “Bayan Khundii Gold Project Feasibility Study NI 43- 101 Technical Report” нэртэй тайлан дахь Баянхөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Компани нь шинэчилсэн ТЭЗҮ боловсруулан, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг хэрэгжүүлж байна. 2023 оны эцэст бүтээн байгуулалтын шийдвэрийг гаргана. Түүнээс гадна, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морь болон Алтан Сум хэтийн төлөв бүхий талбай багтдаг.

Алтан Нар Алтны Төсөл

Алтан Нар алтны төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, Эрдэнэ Ресурсийн Баянхөндий алтны төслөөс хойд зүгт 16 км-т оршдог. Эрдэнэ Ресурс нь алт, мөнгө, хар тугалга, цайрын нөөц бүхий Алтан Нар төслийг агуулсан 4,669 га талбайг хамрах Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон, 2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар бүртгэсэн.

Улаан

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 9 дэх жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой.

Зуун Мод Зэс Молибденийн Төсөл ба бусад

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6,041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Молибденийн зах зээлийн үнэ нэмэгдэх үед Зуун Мод зэс-молибденийн төслийг хөгжүүлэх боломжтой. 2021 оны эцэст Компани түүхий эдийн үнийн өсөлттэй холбогдуулан энэхүү төслийн стратеги болон эдийн засгийн үнэлгээг хийсэн нь төслийн үр ашгийг баталгаажуулсан. 2023 оны дундуур хайгуул

хийсэн нь порфирийн томоохон ордын эрдэсжилтийг өргөжүүлж, төслийн эдийн засгийн өгөөжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх боломжтой болов.

## 5. Түрээс

Компани нь 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн 5 жилийн оффисын түрээсийн гэрээ хийсэн. Түүнээс гадна Монгол Улсад 2021 оны 10 сарын 1-ээс эхлэн 2 жилийн оффисын түрээсийн гэрээ хийсэн. Энэхүү түрээс нь баланс дээр түрээсийн өр төлбөр, хөрөнгө ашиглах эрх болон танилцуулсан. Түрээсийн хөнгөлөлт 7%, 15%-аар тооцсон. Монгол дахь оффисын түрээс 2023 оны 6-р сарын 30-ны өдөр дуусгавар болсон тул хөрөнгө ашиглах эрх болон түрээсийн өглөгийн данснаас хасав.

Хөрөнгө ашиглах эрхийн талаар нэмэлт мэдээлэл:

| | | |
|---|---|---|
| 2023.01.01-ний үлдэгдэл | **$** | **73,594** |
| Элэгдэл | | **(38,175)** |
| Борлуулалт | | **(7,946)** |
| Валютын ханшийн зөрүү | | **(549)** |
| 2023.09.30-ны үлдэгдэл | **$** | **26,924** |
| | | |
| 2022.01.01-ний үлдэгдэл | $ | 143,200 |
| Элэгдэл | | (63,645) |
| Валютын ханшийн зөрүү | | (5,961) |
| 2022.12.31-ний үлдэгдэл | $ | 73,594 |

2023 оны 9 сарын 30-ны байдлаар түрээсийн өр төлбөрийн хугацаа дуусах тухай:

| | 1 жилийн дотор | 1 - 2 жил | Нийт |
|---|---|---|---|
| Түрээсийн төлбөр | $ 32,117 | $ - | **$ 32,117** |
| Санхүүгийн зардлууд | (822) | - | **(822)** |
| Нийт төлбөр | **$ 31,295** | **$ -** | **$ 31,295** |

Компанийн Монгол Улс дахь оффис, ажилтнуудын байр болон агуулахын түрээс нь 12 сарын дотор хугацаа дуусна. Компани нь СТОУС 16-ын шаардлагыг эдгээр түрээсийн бүртгэлд тусгахгүй байхаар шийдсэн бөгөөд 2023.09.30-ны өдөр дуусгавар болсон зургаан сарын хугацаанд нийт $72,229 (2022 - $73,502) дүнтэй түрээсийн төлбөрийг зарлагадсанаар бүртгэсэн.

**6. Үндсэн хөрөнгө**

| | Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж, тавилга | Програм хангамж, компьютер | Нийт |
|---|---|---|---|---|
| **Элэгдэл** | | | | |
| 2023.01.01 үлдэгдэл | **$ 115,961** | **$ 468,387** | **$ 222,271** | **$ 806,619** |
| Нэмэгдэл | **272,733** | **193,311** | **33,036** | **499,080** |
| Борлуулалт | **(69,269)** | **-** | **-** | **(69,269)** |
| Валютийн ханшийн шилжилтийн нөлөө | **3,123** | **1,556** | **130** | **4,809** |
| 2023.09.30 үлдэгдэл | **$ 322,548** | **$ 663,254** | **$ 255,437** | **$ 1,241,239** |
| **Элэгдэл ба хорогдол** | | | | |
| 2023.01.01 үлдэгдэл | **$ (42,192)** | **$ (122,854)** | **$ (95,869)** | **$ (260,915)** |
| Элэгдэл | **(11,136)** | **(32,440)** | **(20,282)** | **(63,858)** |
| Борлуулалт | **17,895** | **-** | **-** | **17,895** |
| Валютийн ханшийн шилжилтийн нөлөө | **(204)** | **(246)** | **(102)** | **(552)** |
| 2023.09.30 үлдэгдэл | **$ (35,637)** | **$ (155,540)** | **$ (116,253)** | **$ (307,430)** |
| **Дансны дүн** | | | | |
| 2023.09.30-нд | **$ 286,911** | **$ 507,714** | **$ 139,184** | **$ 933,809** |

| | Тээврийн ба хээрийн тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж, тавилга | Програм хангамж, компьютер | Нийт |
|---|---|---|---|---|
| Зардал | | | | |
| 2022.01.01 үлдэгдэл | $ 130,843 | $ 326,322 | $ 125,890 | $ 583,055 |
| Нэмэгдэл | - | 185,638 | 111,109 | 296,747 |
| Борлуулалт | - | (1,768) | (5,788) | (7,556) |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | (14,882) | (41,805) | (8,940) | (65,627) |
| 2022.12.31 үлдэгдэл | $ 115,961 | $ 468,387 | $ 222,271 | $ 806,619 |
| Элэгдэл ба хорогдол | | | | |
| 2022.01.01 үлдэгдэл | $ (34,523) | $ (98,484) | $ (76,669) | $ (209,676) |
| Элэгдэл | (12,234) | (32,222) | (28,484) | (72,940) |
| Борлуулалт | - | 1,615 | 5,201 | 6,816 |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | 4,565 | 6,237 | 4,083 | 14,885 |
| 2022.12.31 үлдэгдэл | $ (42,192) | $ (122,854) | $ (95,869) | $ (260,915) |
| Дансны дүн | | | | |
| 2022.12.31-нд | $ 73,769 | $ 345,533 | $ 126,402 | $ 545,704 |

## 7. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани нь Алтан Нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“NSR”)-ийг Сэндстормд төлөх үүрэг хүлээсэн. Сэндсторм нь дээрх тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR төлбөр төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын тодорхой шатанд хүрснээр тодорхой хувийг эргэн худалдан авах эрх үүснэ.

## 8. Хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий Алтны Төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“MMC”)-тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- MMC нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмшинэ.
- Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй.
- Эхний үе шатыг 2023 оны 1 сард эцэслэсэн бөгөөд MMC нь хайгуулын хөтөлбөрүүд, Баянхөндий алтны төслийн шинэчилсэн “Техник, Эдийн Засгийн Үндэслэл” (“Feasibility Study” буюу “FS”) (цаашид “ТЭЗҮ”) болон "Уурхайн ашиглалтын хугацаа" (“Life of Mine” буюу "LOM") (цаашид “УАХ”)-ны төлөвлөгөөг санхүүжүүлэх 5 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг ЭМ-д хийсэн.
- Хоёр дахь үе шатанд, шинэчлэгдсэн ТЭЗҮ батлагдсанаар бүтээн байгуулалтын шийдвэр гарахаас өмнө MMC нь хайгуулын болон бүтээн байгуулалтын өмнөх бэлтгэл ажлуудад 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
- Гурав дахь үе шатанд, Баян Хөндий алтны төслийн хувьцаат капиталын эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор MMC нь 30 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.

2023 оны 1 сарын 16-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд MMC-тэй 5 сая ам.долларын хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн гэрээг байгуулсан. 2023 оны 5 сарын 2-ны өдөр Эрдэнэ Монгол ХХК нь Хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд MMC-тэй хоёр дахь 5 сая ам.долларын хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн гэрээг байгуулсан. 2023 оны 8-р сарын 30-ны өдөр Эрдэнэ Ресурс болон MMC “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 30 сая ам.долларын гурав дахь үе шатны 15 сая ам.долларыг хөрвөх зээл байдлаар олгосон. Хөрөнгө оруулалтын гэрээг 2023 оны дөрөвдүгээр улиралд эцэслэхэд нөхцөлийн дагуу Эрдэнэ Ресурсийн охин компани болон Эрдэнэ Монгол ХХК-ийн хувь эзэмшлийг 6.25%, 6.25%, 18.75% байдлаар хөрвүүлэн шилжүүлнэ.

2023 оны 8 сарын 30-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд гурав дахь шатны санхүүжилтийн хаагдаагүй тохиолдолд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн хүүг тогтоосон SOFR хүү дээр 8%-ийг нэмж тооцно. Хуримтлагдсан хүүгийн төлбөрийг 2024 оны 6-р сарын 30-ны өдрөөс өмнө эсвэл компаниудын хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ дуусгавар болсноос хойш 60 хоногийн дотор төлөх ёстой.

Нягтлан бодох бүртгэлд дээрх хэлцэл нь зээлийн нөхцөл болон өрийн бичгийн хөрвөх нөхцөлийг хослуулсан холимог санхүүгийн өр төлбөрт багтана. Компани нь үндсэн зээлийн өр төлбөр болон хөрвүүлэх опционыг ашиг, алдагдлаар бодит үнэ цэнээр тооцдог бөгөөд энэ нь хөрвөх боломжтой

зээлийн үндсэн дүн болно. Хөрвөх хугацаа харьцангуй богино тул гүйлгээний үнэ болон хуримтлагдсан хүүгийн дүн нь бодит үнэлгээтэй тэнцүү байх төлөвтэй байна..

2023 оны 9 сарын 30-ны өдөр дуусгавар болсон есөн сарын хугацаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн үнэ цэнд орсон өөрчлөлт:

| | | **2023.09.30** |
|---|---|---|
| 2023.01.01 үлдэгдэл | **$** | **-** |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн олголт | | **33,727,003** |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | | **226,733** |
| 2023.09.30 үлдэгдэл | **$** | **33,953,736** |

2023 оны 10 сарын 12-ны өдөр Стратегийн түншлэлийн хөрөнгө оруулалтын гэрээнд хоёр дахь нэмэлт өөрчлөлт оруулснаар 2023 оны 10 сарын 15-ны өдөр ММС нь үлдэгдэл 15 сая ам.долларыг дөрөв дэх өрийн бичиг хэлбэрээр шилжүүлсэн. Сүүлийн 15 сая.долларын хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг нь ЭМ-ийн 18.75%-ийн хувьцаанд хөрвүүлэх төлөвтэй байна.

## 8. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Варрант

2022, 2023 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 9 сарын хугацаанд дахьваррантын мэдээллийг доор харуулав:

| | **2023.09.30** | | | **2022.09.30** | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Варрантын тоо** | **Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ** | | **Варрантын тоо** | **Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ** | |
| 1 сарын 1-ний байдлаар | **25,264,122** | **$** | **0.42** | 44,845,052 | $ | 0.60 |
| Гаргасан | **-** | | **-** | 12,203,670 | | 0.45 |
| Хугацаа дууссан | **-** | | **-** | (44,845,052) | | 0.60 |
| 9 сарын 30-ны байдлаар | **25,264,122** | **$** | **0.42** | 12,203,670 | $ | 0.45 |
| 9 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой | **25,264,122** | **$** | **0.42** | 12,203,670 | $ | 0.45 |

2023 оны 9 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтойваррантын хугацаа 2024 оны 7,8 болон 12 сард дуусна.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр (ХСУБХ буюу “Omnibus plan”) баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж ("ХБХН” буюу ”RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ. ХСУБХ нь

батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болтол хүчинтэй.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааний тоо хэмжээ нь (Залгамж халааны төлөвлөгөөгөөр олгосон урамшууллыг багтаасан) Компанийн гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-иас хэтрэхгүй байх ёстой.

2023 оны 9 сарын 30-ны байдлаар Компани нь $1,505,227 бүхий хувьцаанд суурилсан урамшуулал олгосон (2022 - $921,712) бөгөөд энэ нь ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон ИОХЭ болон опционы бодит үнэ цэнтэй тэнцүү. ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллын дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулав:

Хувьцааны опцион

Компани нь Залгамж халааны төлөвлөгөөний дагуу 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр (“Хөтөлбөр”) хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнууд компанийн хувьцааг худалдан авах опционыг худалдан авч, хэрэгжүүлэх боломжтой. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой. Одоогийн байдлаар хэрэгжиж байгаа опцион нь хөтөлбөрийн нөхцөлийн дагуу олгогдсон.

2022, 2023 оны 9 сарын 30-ны байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

| | 2023.09.30 | | | 2022.09.30 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Опцион тоо | | Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ | Опцион тоо | | Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ |
| 1 сарын 1-ний байдлаар | **17,555,000** | **$** | **0.36** | 15,855,000 | $ | 0.45 |
| Олгосон | **6,325,000** | | **0.36** | 4,180,000 | | 0.31 |
| Хугацаа дууссан | **(3,080,000)** | | **0.40** | (2,595,000) | | 0.87 |
| Хэрэгжсэн | **(100,000)** | | **0.20** | (60,000) | | 0.29 |
| 9 сарын 30-ны байдлаар | **20,700,000** | **$** | **0.35** | 17,380,000 | $ | 0.36 |
| 9 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлсэх боломжтой | **20,700,000** | **$** | **0.35** | 17,380,000 | $ | 0.36 |

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“DSU”)

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийг Компани 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Эрдэнэ Ресурсийн ИОХЭ-ийн төлөвлөгөөний дагуу ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал эсхүл гишүүдээс үзүүлсэн үйлчилгээ зэрэгт урамшуулал олгох бөгөөд ТУЗ-ийн зүгээс тогтоосон тоо, цаг хугацааны хүрээнд олгож болно. Урамшуулал олгох огноогоор ИОХЭ хэрэгжиж шилжүүлэгдэнэ. Төлөвлөгөөнд хамрагдах гишүүний гэрээ дуусгавар болсон эсвэл нас барсан тохиолдолд компанийн зүгээс өөрийн эрхийн хүрээнд зах зээлийн үнээр эсвэл хувьцаагаар олголт хийж болно. Тус олголтын хүрээнд компанийн өөрийн эрхийн дагуу бэлэн мөнгөөр олгохгүй тул хөрөнгийн данснаас барагдуулах төлөвлөгөө болгон бүртгэнэ. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан ХСУБХ-ийн дагуу гаргасан ИОХЭ нь ИОХЭ төлөвлөгөөний нөхцөлтэй нийцэж байна.

2023 оны 9 сарын 30-ны байдлаар Компани нь нэгж тус бүрийг $0.32 доллараар үнэлсэн 1,312,535 ширхэг ИОХЭ (2022 - $0.32 үнэлсэн 958,301 ширхэг ИОХЭ олгосон)-ийг компанийн ХСУБХ болон Залгамж халааны төлөвлөгөөнд үндэслэн олгосон. Бодит үнэлгээ нь $426,951 (2022 – $308,433) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан. 2023 оны 9 сарын 30-ны байдлаар дуусгавар болсон есөн сарын хугацаанд Эрдэнэ Ресурс нь ИОХЭ төлөвлөгөөнөөс 17,614 ширхэг хувьцааг нэгж үнэ нь 0.37 доллараар гаргасан байна (2022 - 0).

2022, 2023 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон есөн сарын хугацаанд олгогдсон ИОХЭ урамшууллын 5 өдрийн жигнэсэн дундаж ханшийг харуулав:

| | **2023.09.30** | 2022.09.30 |
|---|---|---|
| | **Тоо ширхэг** | **Тоо ширхэг** |
| 1 сарын 1-ний байдлаар | **7,287,272** | 6,103,362 |
| Олгосон | **1,312,535** | 958,301 |
| Гаргасан | **(17,614)** | - |
| 9 сарын 30-ны байдлаар | **8,582,193** | 7,061,663 |

| | **2023.09.30-нд дуусгавар болсон** | **2022.09.30-нд дуусгавар болсон** |
|---|---|---|
| Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ | **$ 0.33** | $ 0.32 |

## 10. Хайгуул болон үнэлгээний зардал

2022, 2023 оны 9 сарын 30-ны байдлаар дуусгавар болсон гурав болон есөн сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав:

| | **9.30-аар дуусгавар болсон гурван сар** | | **9.30-аар дуусгавар болсон есөн сар** | |
|---|---|---|---|---|
| | **2023** | **2022** | **2023** | **2022** |
| Элэгдэл | **$ 12,043** | $ 25,206 | **$ 42,984** | $ 71,917 |
| Шууд зардал | **384,206** | 554,730 | **1,126,349** | 2,106,940 |
| Ажилтан, албан тушаалтнуудын зар | **140,058** | 207,482 | **409,024** | 562,796 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | **152,919** | 367,831 | **664,229** | 407,304 |
| | **$ 689,226** | $ 1,155,249 | **$ 2,242,586** | $ 3,148,957 |

## 11. Захиргаа, удирдлагын зардал

2022, 2023 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын хугацаанд захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав:

| | 9.30-аар дуусгавар болсон гурван сар | | 9.30-аар дуусгавар болсон есөн сар | |
|---|---|---|---|---|
| | **2023** | **2022** | **2023** | **2022** |
| Захиргааны үйлчилгээ | **$ 188,928** | $ 258,936 | **$ 754,268** | $ 552,817 |
| Элэгдэл, хорогдол | **9,193** | 9,526 | **27,787** | 28,573 |
| ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, нөхөн тө | **26,250** | 25,250 | **89,994** | 94,504 |
| Хөрөнгө оруулагчтай харилцах, марк | **79,121** | 33,576 | **245,766** | 100,885 |
| Оффис, бусад | **26,980** | 26,098 | **81,045** | 76,580 |
| Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | **100,532** | 100,211 | **349,104** | 266,325 |
| Зохицуулагч байгууллагын төлбөр | **16,894** | 13,796 | **108,858** | 114,353 |
| Хувьцаанд суурилсан нөхөн олговор | **142,083** | 395,887 | **840,998** | 514,408 |
| Томилолтын зардал | **10,614** | 7,007 | **74,341** | 42,887 |
| | **$ 600,595** | $ 870,287 | **$ 2,572,161** | $ 1,791,332 |

## 12. Санхүүгийн хэрэглүүр

**Зээлийн эрсдэл:**

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдэлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл хамгийн их хүлээж буй хөрөнгийг харуулбал:

| | Дансны дүн | |
|---|---|---|
| | **9 сарын 30 2023** | **12 сарын 31 2022** |
| Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах | **$ 28,283,697** | $ 7,421,600 |
| Авлага | **77,144** | 76,582 |
| | **$ 28,360,841** | $ 7,498,182 |

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлийг удирддаг.

**Төлбөрийн чадварын эрсдэл:**

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

**Зах зээлийн эрсдэл:**

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, тавaарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

a) Хүүгийн эрсдэл

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэл үүсгэх магадлалтай.

Тодруулга 8-д дурдсан хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийн SOFR хүүд суурилагдах бөгөөд гуравдугаар санхүүжилт хийгдээгүй тохиолдолд 1%-аар нэмэгдэх эсвэл буурахад жилийн хүүгийн зардал ойролцоогоор $337,500 доллараар буурах эсвэл нэмэгдэх магадлалтай.

b) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкнуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Компани нь хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг нь ам.доллараар илэрхийлэгдсэн үнэлгээнд гадаад валютын ханшийн эрсдэлд өртөж байна. Хэрэв MMC-тэй хийсэн стратегийн түншлэлийн гурав дахь үе шат эцэслэгдээгүй тохиолдолд олгосон санхүүжилт болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийг 60 хоногийн дотор төлөх ёстой. Үүний үндсэнд компани канад болон америк долларын ханшийн хэлбэлзлээс үүдэн санхүүжилтийг эргэн төлөх тохиолдолд илүү өртөгтэй байх болзошгүй байна.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

| | | 9 сарын 30 2023 | | 12 сарын 31 2022 |
|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах | **$** | **24,396,683** | $ | 311,141 |
| Худалдаа, бусад өглөг | | **(11,517,210)** | | (215,506) |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг | | **(33,953,736)** | | - |
| | **$** | **(21,074,263)** | $ | 95,635 |

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь $2,107,400 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2022.12.31 - $9,600).

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

| | | 9 сарын 30 2023 | | 12 сарын 31 2022 |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах | **$** | **29,444** | $ | 35,194 |
| Худалдаа, бусад авлага | | **71,321** | | 69,559 |
| Худалдаа, бусад өглөг | | **(16,825)** | | (61,274) |
| | **$** | **83,940** | $ | 43,479 |

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь $8,400 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2022.12.31 - $4,300).

c) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

**Бодит үнэ цэн:**

Компанийн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь дансны үнэтэй ойролцоо гэж үздэг. Бодит үнэ цэн нь тооцох өдөр зах зээлд оролцогчдын хооронд хийсэн хэлцлийн дагуу хөрөнгийг худалдахад хүлээн авах эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ юм. Бодит үнэ цэний түвшин нь бодит үнэ цэнийг ангилан хэмжихэд ашигласан үнэлгээнд тогтоодог:

a) Түвшин 1: Хөрөнгө болон өр төлбөрийн зах зээл дэх үнэ;

b) Түвшин 2: Түвшин 1-д тогтсон зах зээлийн үнээс бусад шууд болон шууд бусаар тогтоогдох үнэ;

c) Түвшин 3: Зах зээлийн үнээс үл хамаарсан байдлаар тогтоогдох үнэ.

Дараах хүснэгтэд хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэний ангилсан түвшин харуулав:

| | 2023.09.30 | | | 2022.12.31 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Түвшин 1** | **Түвшин 2** | **Түвшин 3** | **Түвшин 1** | **Түвшин 2** | **Түвшин 3** |
| Хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ | | | | | | |
| Хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг | **$ -** | **$ -** | **$ 33,953,736** | $ - | $ - | $ - |

## 13. Холбогдох талууд

Компанийн голлох удирдах ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

| | 9 сарын 30 | |
|---|---|---|
| | **2023** | **2022** |
| ТУЗ-ийн гишүүдийн цалин | **$ 122,750** | $ 93,750 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | **466,400** | 255,625 |
| Ажилтнуудын цалин, урамшуулал | **1,319,485** | 1,163,036 |
| Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан урамшуулал | **483,747** | 311,598 |
| | **$ 2,392,382** | $ 1,824,009 |

*Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө*